



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/27

Арвайхээр

**Г Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах
журам батлах тухай**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг" тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, дотоод хяналт шалгалтын 2023 оны жилийн ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, дотоод хяналтын багийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дотоод хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, улирал бүр үр дүнг тайлагнан ажиллахыг гүйцэтгэлийн удирдлага, дотоод хяналтын албаны дарга (Д.Аззаяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Баянмөнх)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Г.ДАШЖАНЦАН